



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 469

Чингис хот

Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх
орон тооны бус байнгын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дох заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 3.2, 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, хоршоо, нөхөрлөлийн гишүүн хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Лхагвабаатар - Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	А.Алимаа - Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Алтантөгс - Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
Зөвшилцсөнөөр:	Ажил олгогчийн төлөөлөл Ажилтны төлөөлөл

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн осол, хурц хордлогын шалтгааныг тогтоож ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР